



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 27 өдөр

Дугаар А/251

Бат-Өлзий сум

Эргүүлийн хуваарь батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.10, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шинэ жилийн баярыг тохиолдуулан нийгмийн хэв журам сахиулах, аж ахуйн нэгж, байгууллагуудын хэвийн ажиллагааг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн амгалан тайван, аюулгүй байдал, эрх ашгийг хамгаалахад хяналт тавьж, зохицуулах албан хаагчдын хариуцлагатай эргүүлийн хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ), Цагдаагийн тасгийн дарга, (Цагдаагийн хошууч Энх-Амгалан) нарт ДААЛГАХ нь:

а. Эргүүлээр ажиллах албан хаагчдад үүрэг даалгавар өгч батлагдсан хуваарийн дагуу ажиллуулах.

б. Баярын үеэр гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажлыг шуурхай зохион байгуулах.

в. Гарсан гэмт хэрэг, зөрчлийн талаар сумын удирдлага, холбогдох байгууллагад яаралтай мэдэгдэж унаа, хүн хүчний туслалцаа авч ажиллах.

г. Эргүүлээр ажилласан ажлын дүнг нэгтгэн 2024 оны 01 дүгээр сарын 05-ны дотор танилцуулах.



ОРЛОГЧ Н.ОРХОНТУУЛ

Сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/251 дугаар захирамжийн хавсралт



ХӨДӨЛГӨӨНТ ЭРГҮҮЛИЙН ХУВААРЬ

Д/д	Төрийн байгууллагын нэр	Эргүүлээр ажиллах хугацаа (өдөр бүр 18:00 цагаас 24:00 цаг)	Хөдөлгөөн эргүүлийн авто машин
1	ЭМТөв	2023 оны 12 дугаар сарын 29-ний өдөр	Цагдаагийн тасгийн 56-66 ӨВЕ дугаартай фургон маркийн авто машин
2	ЗДТГазар	2023 оны 12 дугаар сарын 30-ны өдөр	Цагдаагийн тасгийн 56-66ӨВЕ дугаартай фургон маркийн авто машин
3	Ерөнхий боловсролын сургууль	2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр	Цагдаагийн тасгийн 56-66 ӨВЕ дугаартай фургон маркийн авто машин
4	1 дүгээр Цэцэрлэг	2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр	Цагдаагийн тасгийн 56-66 ӨВЕ дугаартай фургон маркийн авто машин
5	2 дугаар Цэцэрлэг	2024 оны 01 дүгээр сарын 02 -ны өдөр	Цагдаагийн тасгийн 56-66 ӨВЕ дугаартай фургон маркийн авто машин

Жич: Албан байгууллага бүрээс 2 албан хаагч, Цагдаагийн тасгийнхантай хамтран ажиллана.